


БАТЛАВ. ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА

Б.Биндэръяа

Б.БИНДЭРЪЯА



ДАЛАЙН ЗАХИРГААНААС АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР
2022 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.01.25

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
1.	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар АТГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж биелэлтэд хяналт тавьж ажиллах;	1-р сард	Захиргаа, удирдлагын хэлтэс, Байгууллагын ХШДАЗ	Төлөвлөгөө батлагдсан байна.
2.	Байгууллагын удирдах болон эрх бүхий албан тушаалтны Албан тушаалын тодорхойлолтыг эрхлэх асуудал, ажлын байрны чиг үүрэг, албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагад нийцүүлэн нэгдсэн стандартын дагуу шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;	1-р улиралд	Захиргаа, удирдлагын хэлтэс, Байгууллагын ХШДАЗ	Албан тушаалтныг мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилж, дэвшүүлж хэвшүүлэх.
3.	Нийтийн албаны томилгоо, сул орон тоо гарсан тохиолдолд сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод болгож, иргэдийг нийтийн албанд орох адил тэгш боломжоор хангах, нийтийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангуулах арга хэмжээг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	1-р улиралд	Захиргаа, удирдлагын хэлтэс, Байгууллагын ХШДАЗ	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал сайжирна.
4.	Төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан улмаар авлига, албан тушаалын болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийг нийтийн албан тушаалд томилохгүй байх талаар холбогдох журамд тусган дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах;	Жилдээ	Байгууллагын ХШДАЗ	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны манлайлал, ёс зүйн байдал дээшилнэ.

5.	Нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, давхар ажил эрхлэлттэй холбоотой ажил, үүргийг гүйцэтгэхгүй байх талаар холбогдох журамд тусган хэрэгжүүлэх;	Жилдээ	Захиргаа, удирдлагын хэлтэс	Нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтэд тавих хяналт сайжирч энэ төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлнэ.
6.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаанд хяналт тавих талаар холбогдох зөвлөлийн ажиллах журам, ажлын төлөвлөгөөнд тусган ажиллах;	Жилдээ	Байгууллагын ХШДАЗ	Төсөв, санхүү, Худалдан авах ажиллагааны сахилга, хариуцлага сайжирна.
7.	Бусдад давуу байдал олгох, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах буюу хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээдтэй холбоотой тушаал шийдвэр гаргах, гаргахад оролцох, гэрээ, хэлцэл байгуулах, албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөх зэрэг авлига, ашиг сонирхлын зөрчлийг гаргахгүй байх талаар Ажилтны ёс зүйн дүрэм болон тэдэнтэй байгуулах Хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлж ажиллах;	Жилдээ	Захиргаа, удирдлагын хэлтэс Байгууллагын ХШДАЗ	Ажилтны ёс зүй, үүрэг хариуцлага дээшилнэ.
8.	Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөж болзошгүй эрсдэлт ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн гаргаж баталгаажуулах;	Жилдээ	Захиргаа, удирдлагын хэлтэс	Хөрөнгө орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтны хүрээг оновчтой тогтоох талаарх хөтөлбөрийн хэрэгжилт сайжирна.
9.	Гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулах, Төндөр, сонгон шалгаруулалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа албан тушаалтнаар хувийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргуулж хэвшүүлэх;	Жилдээ	Захиргаа, удирдлагын хэлтэс	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт сайжирна.
10	Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийн тайланг улирал бүр гаргаж яамны ТЗУГ-т хүргүүлнэ.	Жилдээ	Захиргаа, удирдлагын хэлтэс	Зөвлөмжийн хэрэгжилт сайжирна.